



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 07 сарын 12 өдөр


Дугаар 45

Мандалговь

Хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Байгууллагын батлагдсан төсөвт зардлаас 3 нэр төрлийн 299,800 /хоёр зуун ерэн есөн мянга найман зуун/ төгрөгийн эд хөрөнгийг хавсралтын дагуу бэлтгэхийг Орон нутгийн өмчийн газарт зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгийг зохих хууль журмын дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.



ДАРГА

С.СҮХБААТАР

0100038

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны ...  
сарын ... өдрийн ..... дугаар тогтоолын хавсралт

Бэлтгэх хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Телефон аппарат	1	144,900	144,900
2	Компьютерийн гар	1	34,900	34,900
3	Дрилл	1	120,000	120,000
Дүн				299,800